НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 04 өдөр Дугаар А/25 Улаанбаатар хот

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГ
БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалтууд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг (ҮАГ-НАГ/2017/-05-НА) баталсугай.

2. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, нийслэлийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР С.ЭНХБААТАР

D:\2017 on\Tushaal\2017.08.04_NA_tailan_batalgaajuulah.docx

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Төрийн аудитын тухай хуулийн 15.1.15, Сонгуулийн тухай хуулийн 39.4 дэх заалт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын нэр:
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл

2017 он

УАГ-НАГ/2017/-05-НА

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

НТАГ-ын Нийцлийн аудитын хэлтэс

Аудитын менежер

Б.Мөнх-Очир

Нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор

Д.Ичин

Аудитор

Г.Цогтбаатар

С.Лхагвасүрэн

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Дэд зорилт–1:	5
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;	
Дэд зорилтын 1-ын дүгнэлт: Нийслэлийн сонгуулийн хороо нь холбогдох журмыг үндэслэн сонгуулийн хороодод төсвийг хуваарилж, зориулалтын дагуу зарцуулжээ.	5-6
Дэд зорилт–2:	
Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх;	7
Дэд зорилт 2-ын дүгнэлт: Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан боловч гүйцэтгэлийн тайлан тодруулгагүй, дүүргийн сонгуулийн хороодын сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг журамд заасны дагуу хэрэгжүүлээгүй байна.	7-10

Уг тайланг НТАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.
http://city.audit.mn/
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар лавлах

Утас 976-11-327787

Дүгнэлт 11

Холбогдох байгууллагын санал 12

Нийслэл дэх төрийн аудитын газрын тайлбар 13

Хавсралтууд 14-17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НСХ	Нийслэлийн сонгуулийн хороо
ДСХ	Дүүргийн сонгуулийн хороо
БЗД	Баянзүрх дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
БНД	Баганууур дүүрэг
НД	Налайх дүүрэг
БХД	Багахангай дүүрэг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх;

- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ: Аудитад нийслэл, дүүргийн сонгуулийн хороодыг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитыг Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэл болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан сонгуульд зарцуулсан төсвийг анхан шатны баримт, журналтай тулгах, хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа авах, дүн шинжилгээ хийн аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан тайлагнаж, дүгнэлт гаргав.

Аудитад ашигласан шалгуур: Аудитад Төсвийн, Төрийн аудитын, Сонгуулийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”, холбогдох бусад эрх зүйн акт, стандартуудыг ашигласан болно.

Аудитыг Нийслэлийн дэх Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Мөнх-Очир удирдаж, Нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Д.Ичин, аудитор Г.Цогтбаатар, С.Лхагвасүрэн нар 2017 оны 7 дугаар сарын 16-наас 2017 оны 8 дугаар сарын 4-ийг хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Тайлангийн төсөлд санал авахаар Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2017 оны 8 дүгээр сарын 4-ний 1107 тоот бичгээр НСХ-д хүргүүлж, НСХ-ны 2017 оны 8 дүгээр сарын 4-ны өдрийн 80 дугаар албан бичгээр санал ирүүлсэн. Аудитын тайланг НТАГ-ын дарга, Тэргүүлэх аудиторын 2017 оны 8 дүгээр сарын 4-ний өдрийн А/25 дугаар тушаалаар батлав.

1	**Дэд зорилт-1: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;**
	Нийслэлийн сонгуулийн хороо нь холбогдох журмыг үндэслэн сонгуулийн хороодод төсвийг хуваарилж, зориулалтын дагуу зарцуулжээ.

Ерөнхий мэдээлэл:

СЕХ-ны 2017 оны 4 дүгээр сарын 12-ны 10 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах нийслэлийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй баталжээ.

НСХ нь Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн 2017 оны 4 дүгээр сарын 21-ний 01 дүгээр тогтоолоор сонгуулийг зохион байгуулах дүүргүүдийн сонгуулийн хороог тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэй баталжээ.

Нийслэлийн хэмжээнд нийт 403 хэсгийн хороог зохион байгуулж, сонгуулийн үйл ажиллагааг явуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль болон дахин санал хураалтын зардалд нийт улсын төсвөөс 1 840 595.8 мянган төгрөг олгохоор СЕХ хуваарилалт хийжээ.

1.1.Төсвөөс олгох хөрөнгийг сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан эсэх.

Нийслэлийн сонгуулийн хороо СЕХ-ны 2017 оны 4 дүгээр сарын 26-ны 113, 5 дугаар сарын 30-ны 172, 6 дугаар сарын 13-ны 199, 6 дугаар сарын 21-ний 210, 7 дугаар сарын 18-ны 295 дугаар албан бичиг болон тайлбарыг үндэслэн нийслэл, дүүргийн сонгуулийн хороодод сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж, хөрөнгийг хуваарилан санхүүжилтийг шилжүүлжээ.

НСХ нь СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.2 дахь заалтыг үндэслэн эдийн засгийн ангиллын дагуу дүүргүүдийн санал авах байрны тоо, алслалт, хүн амын тоог харгалзан бичиг хэрэг, шуудан холбоо, унаа, томилолт, саналын хуудас болон санал тоолох төхөөрөмжийн хүргэлт, буцаалтын зардлыг хуваарилсан байна. /Хуваарийг хавсралт №01,02/

НСХ-оос 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 60 тоот албан бичгээр СЕХ-д сонгуулийн зардлыг төсөв хооронд шилжүүлэн зарцуулах талаар хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлсний дагуу хууль тогтоомж сурталчлах зардлаас 27 134.7 мянган төгрөг, сургалтын зардлаас 6 850.0 мянган төгрөг, нийт 33 984.7 мянган төгрөгийг

болзошгүй зардалд 19 354.7, бичиг хэрэгт 420.0, шатахуунд 560.0, урамшуулалд 13 650.0 мянган төгрөгийг шилжүүлэн хуваарилжээ.

НСХ нь холбогдох журам, СЕХ-ноос ирүүлсэн тайлбарыг үндэслэн нийслэл, дүүргийн сонгуулийн хороодод сонгуулийн хөрөнгийг хуваарилжээ.

1.2. Хуваарилсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулсан эсэх

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн зардалд улсын төсвөөс нийт 1 840 595.8 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1 840 595.8 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

Улсын төсвөөс олгосон санхүүжилт

/мянган төгрөг/

№	Санал хураалтын үе шат	Дүүрэг	Нийт дүн		
			Батлагд сан төсөв	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	1	Сүхбаатар	169 726.4	169 726.4	-
	2		14 133.0	14 133.0	
2	1	Чингэлтэй	163 594.9	163 594.9	-
	2		13 560.0	13 560,0	
3	1	Баянзүрх	371 799.2	371 799.2	-
	2		29 930.0	29 930.0	
4	1	Баянгол	252 915.2	252 915.2	-
	2		19 905.0	19 905.0	
5	1	Сонгинохайрхан	353 229.8	353 229.8	-
	2		30 205.0	30 205.0	
6	1	Хан-Уул	182 841.4	182 841.4	-
	2		15 705.0	15 705.0	
7	1	Налайх	54 598.2	54 598.2	-
	2		4 145.0	4 145.0	
8	1	Багахангай	14 986.8	14 986.8	-
	2		1 435.0	1 435.0	
9	1	Багануур	43 177.0	43 177.0	-
	2		3 715.0	3 715.0	
10	1	Нийслэл	94 203.9	94 203.9	-
	2		1 390.0	1 390.0	
нийт	1	1 Дүн	**1 701 072.8**	**1 701 072.8**	
	2	2 дүн	**139 523.0**	**139 523.0**	
		нийт дүн	**1 840 595.8**	**1 840 595.8**	

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон 1 840 595.8 мянган төгрөгийн санхүүжилтээс 1 831 395.1 мянган төгрөг буюу нийт санхүүжилтийн 99.5%-ийг зарцуулж, үлдэгдэл 9 200.7 мянган төгрөгийг СЕХ-ны Төв төрийн сан дахь 100900022001 тоот дансанд буцаан төвлөрүүлжээ.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэл

1. Эхний шатны санал хураалтын төсвийн гүйцэтгэл

/ мян.төгрөг/

№	Дүүрэг	Нийт дүн		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сүхбаатар	169 726.4	169 729.4	-3.0
2	Чингэлтэй	163 594.9	163 593.9	1.0
3	Баянзүрх	371 799.2	368 637.7	3 161.5
4	Баянгол	252 915.2	252 915.2	-
5	Сонгинохайрхан	353 229.8	353 229.8	-
6	Хан-Уул	182 841.4	182 841.4	-
7	Налайх	54 598.2	52 245.7	2 352.5
8	Багахангай	14 986.8	14 986.8	-
9	Багануур	43 177.0	42 244.6	932.4
10	Нийслэл	94 203.9	93 188.6	1 015.3
	Дүн	**1 701 072.8**	**1 693 613.2**	**7 459.6**

2. **Дахин санал хураалтын төсвийн гүйцэтгэл**

/ мян.төгрөг/

№	Дүүрэг	Нийт дүн		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Баянгол	19 905.0	19 905,0	
2	Баянзүрх	29 930.0	29 150.0	780.0
3	Хан-Уул	15 705.0	15 705.0	
4	Чингэлтэй	13 560.0	13 560.0	
5	Сүхбаатар	14 133.0	14 130.0	3,0
6	Сонгинохайрхан	30 205.0	30 205.0	
7	Налайх	4 145.0	4 145.0	
8	Багануур	3 715.0	3 551.9	163.1
9	Багахангай	1 435.0	1 435.0	
10	Нийслэл	6 790.0	5 995,0	795.0
	Дүн	**139 523.0**	137 781.9	**1 741.1**

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

○ **Дэд зорилт-2: Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх;**

2

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан болов гүйцэтгэлийн тайлан тодруулгагүй, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг журамд заасны дагуу хэрэгжүүлээгүй байна.

2.1. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан эсэх

Сонгуулийн тухай хуулийн 38 дэх заалт, СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор баталсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлагналыг авч үзвэл дараах байдалтай байна.

Нийслэл, дүүргийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн зарцуулалтыг холбогдох баримт материалтай нь тулган шалгахад сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээнд гарч болох эрсдэл, гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, чанар, түүний шалгуурыг хэрхэн тооцох талаар тодорхой тусгаагүй, хавсралтгүй, хүлээн авсан акт зэрэг нь хэт ерөнхий, нотариатаар баталгаажуулаагүй зэрэг зөрчил нийтлэг байв.

Нийслэл, дүүргийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн зарцуулалтыг анхан шатны баримт материалтай тулган шалгахад нийт 15 470.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ○ СБД-ийн сонгуулийн хороо анхан шатны баримтыг зохих ёсоор бүрдүүлэхгүйгээр нийт 8 955.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор баталсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 4.1.[1] заалтыг зөрчжээ.
- ○ СБД-ийн сонгуулийн хороо иргэнтэй байгуулсан байрны түрээсийн зардлаас 250.0 мянган төгрөгийн татвар суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.1[2] заалтыг хэрэгжүүлээгүй;
- ○ БЗД-ийн сонгуулийн хороо унааны зардал тооцсон 545.0 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв хөтлөөгүй;
- ○ БГД-ийн сонгуулийн хороо саналын хуудас болон санал тоолох төхөрөөмж хүргэх, авч ирэх 660.0 мянган төгрөгийн ажлыг гэрээгүйгээр гүйцэтгүүлсэн;
- ○ Мөн сонгуулийн санал авах байрны засварын 5 048.1 мянган төгрөгийн ажлын тоо хэмжээ тодорхойгүй, хүлээн авсан акт үйлдээгүй;

---

[1] *"Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтлөнө."*

[2] *"энэ хуулийн 11 дүгээр зүйл, ... заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, ... тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;"*

- БНД-ийн сонгуулийн хороо эрчим хүчний эх үүсвэрт олгосон 57.4 мянган төгрөгийн тооцоо хийгээгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*."5.1.4 "*үнэн зөв байх*", СЭЗС, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 тоот тушааалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх заавар*"-ын 6.4 "...хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана."* гэсэн заалтыг зөрчжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн арга хэмжээнд нийт 1,831,395.1 мянган төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төсвийг 9,200.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ. Үүнд: Санал авах байр бэлтгэхэд 73.2, бичиг хэрэгт 108.7, сургалтанд 591.0, шуудан холбоонд 355.3, унаанд 82.4, хууль тогтоомж сурталчлахад 367.9, мэдээ дамжуулалтад 350.0, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж хүргэлтэд 1430.0, эрчим хүчний эх үүсвэр, болзошгүй зардалд 4135.6, сонгуулийн ажилтнуудын урамшуулал, хоолонд 1713.6 мянган төгрөг зарцуулжээ. /Хавсралт №03/.

Дүүргийн сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг хийж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54.5.5.[3], СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 4.3.[4] заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг хавсралт №04-өөр харуулав.

НТАГ энэ удаагийн аудитыг хийхдээ дүүргийн сонгуулийн хороодоос хуульд заасан үүрэгтээ хэрхэн хандаж байгаад зохих хэмжээний анхаарал хандууллаа. "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-д заасан хугацаанд тайлангаа ирүүлэх талаар НТАГ дүүргийн сонгуулийн хороодоос удаа дараа шаардаж байж холбогдох баримтуудыг гаргуулж авлаа. Сонгуулийн хороод хууль болон журамд заасан хугацаанд баримтуудыг өөрсдөө ирүүлэх үүрэгтэй байтал тэр үүргээ анхаарч хэрэгжүүлэхгүй, аудитын байгууллагаар шаардуулж байдаг зөрчил давтагдсаар байна.

НСХ-ны санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг СЕХ 2 хоногоор хэтрүүлж нээсэн, Төрийн сан банкны сүлжээ 2017 оны 7 дугаар сарын 21-нээс 24 хүртэл 3 өдөр тасарсан зэрэг хүчин зүйлс тайлангийн хугацааг хожимдуулахад нөлөөлсөн гэж НСХ-ноос гаргасан тайлбарыг бодитой гэж үзэж байна.

ХУД-ийн сонгуулийн хороо тайлан хүргүүлсэн тухай тоотыг албан бланк дээр биш, цулгуй цагаан цаасан дээр бичиж ирүүлсэн нь төрийн албаны бичиг хэрэг хөтлөлтийн шаардлагуудыг үл ойшоосон ёс зүйгүй үйлдэл болж байна.

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна. Гэвч нийслэл, дүүргийн сонгуулийн хороо гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг ирүүлээгүй, зарим дүүргийн

---

[3] *"Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга"*

[4] *"Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ: ... 4.3.2. тайлангийн товч танилцуулга, тодруулга; ..."*

сонгуулийн хорооны гүйцэтгэлийн тайлан нь анхан шатны баримтын бүрдэлт дутуу, ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний биелэлт зохих шаардлагыг хангаагүй байна.

2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, журмын дагуу гүйцэтгэсэн эсэх

Энэ аудитаар нийслэл, дүүргийн сонгуулийн хороодод 15 470.5 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн нь НСХ дүүргийн сонгуулийн хороодын сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих хяналт бүрэн дүүрэн хэрэгжсэн гэж дүгнэх боломжгүй байдалд хүргээд байна.

Дээрх зөрчил, дутагдал нь СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4.[5], 4.1.[6] дахь заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс үүдэлтэй. Гэхдээ энэ зөрчил нь үнийн дүнгээрээ сонгуулийн нийт зардлын 0.8%-ийг эзэлж байгаа юм.

[5] *“ ... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны ... сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина.”*

[6] *“Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтлөнө.”*

ДҮГНЭЛТ:

1. **Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг зохион байгуулахдаа НСХ нь хуваарилагдсан төсвийг холбогдох журмын дагуу дүүргийн сонгуулийн хороодод хуваарилж, зориулалтын дагуу зарцуулж, сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагналаа.**

2. **Сонгуулийн зардлын хуваарилалт, зарцуулалтад зөрчил гаргаагүй боловч гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг гаргаж ирүүлээгүй, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.**

3. **Нийт дүнгээр нийслэл, дүүргийн сонгуулийн хороод 15 470.5 мянган төгрөгийн зөрчил, дутагдал гаргасан боловч энэ нь харьцангуй үзүүлэлтээрээ маш бага байгаа юм. Өмнөх оны УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлээр 12.1%-ийн зөрчил илэрч байсан бол энэ удаагийн сонгуулийн зардалд 0.8%-ийн зөрчил илэрсэн нь сонгуулийн хороодын зардлын зарцуулалт сайжирсныг харуулж байна.**

4. **Цаашид сонгуулийн хороод зардлын тайлан гаргах бэлтгэл ажил, цаг хугацаанд онцгойлон анхаарч ажиллахыг зөвлөж байна.**

Холбогдох байгууллагын санал

НИЙСЛЭЛИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 7
Утас: 32-17-31, Факс: (976-11) 32-17-31

2017.08.04 №80
танай_____-ны №_____-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Нийслэлийн сонгуулийн хороонд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн Нийцлийн аудитын тайлан, аудитын дүгнэлт"-тэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй санал нэг байна. Нийслэлийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийг тухай бүр тайлбарын дагуу хуваарилж, санхүүжилтийг дүүргүүдэд олгон, бүртгэл санхүүгийн удирдлагаар ханган ажилласан бөгөөд зарим дүүргүүдийн сонгуулийн хорооны санхүүгийн ажилтны хариуцлагагүй байдлаас шалтгаалан 15,5 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зөрчил илэрсэн байна.

Цаашид аудитын дүгнэлтээр гарсан зөрчлийг давтан гаргахгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.

ДАРГА Үн Ганболд Ү.ГАНБОЛД

Нийслэл дэх Төрийн аудитын газрын тайлбар:

Тайлангийн төсөлд санал авахаар Нийслэл дэх төрийн аудитын газрын 2017 оны 8 дугаар сарын 4-ний 1107 тоот албан бичгээр Нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.

Нийслэлийн сонгуулийн хороо нь 2017 оны 8 дугаар сарын 4-ний 80 тоот албан бичгээр "*....Аудитын дүгнэлттэй санал нэг байна. Цаашид аудитын дүгнэлтээр гарсан зөрчлийг давтан гаргахгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно*." гэсэн хариуг ирүүлсэн тул тайланд тайлбар хийх шаардлагагүй гэж үзлээ.

Хавсралт № 01

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ САНАЛ ХУРААЛТЫН ЗАРДЛЫН НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ

2017.08.04 / мян.төг /

№	Зардлын зүйл	Дүүрэг									НСХ	Дүн
		Сонгино-хайрхан	Баянзүрх	Баянгол	Хан-Уул	Сүхбаатар	Чингэлтэй	Налайх	Багануур	Багахангай		
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	25.0	25.0	25.0	25.0	25.0	25.0	25.0	25.0	25.0	25.0	**250.0**
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	0.0	-	-	-	0.0	-	-	-	0.0		**0.0**
3	Сургалтын зардал	1,930.0	1,913.0	1,357.0	1,052.0	967.0	1,052.0	798.0	724.0	395.0	401.0	**10,589.0**
4	Бичиг хэргийн зардал	16,660.0	16,480.0	11,405.0	8,700.0	7,795.0	8,700.0	2,680.0	1,900.0	440.0	800.0	**75,560.0**
5	Шуудан холбооны зардал	16,580.0	16,400.0	11,360.0	8,660.0	7,760.0	8,660.0	2,210.0	1,850.0	410.0	800.0	**74,690.0**
6	Унааны зардал	18,745.0	18,545.0	12,895.0	9,875.0	8,865.0	9,875.0	3,160.0	2,200.0	600.0	2,000.0	**86,760.0**
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	0.0	-	-	-	0.0	-	-	-	0.0	47,865.3	**47,865.3**
8	Санал авах байр бэлтгэх зардал	18,200.0	18,000.0	12,400.0	9,400.0	8,400.0	9,400.0	2,400.0	2,000.0	400.0		**80,600.0**
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	140.0	140.0	140.0		**2,520.0**
10	Томилолтын зардал	0.0	-	-	-	0.0	-	40.0	130.0	130.0		**300.0**
11	Саналын хуудас хүргэх зардал	925.0	915.0	630.0	475.0	425.0	480.0	160.0	230.0	150.0		**4,390.0**
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал	4,220.0	4,200.0	2,770.0	1,960.0	1,740.0	1,690.0	320.0	460.0	300.0		**17,660.0**
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	1,890.0	1,890.0	1,260.0	980.0	903.0	980.0	280.0	210.0	70.0		**8,463.0**
14	Болзошгүй зардал	6,300.0	28,450.0	26,970.0	-	5,000.0	13,166.5	2,162.0	-	0.0	28,590.2	**110,638.7**
15	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хуга-цааны мөнгөн урамшуу-лал, хоолны зардал	267,404.8	264,631.2	171,493.2	141,364.4	127,496.4	109,216.4	40,223.2	33,308.0	11,926.8	8,506.4	**1,175,570.8**
16	Сангалын хуудас устгах зардал										5,216.0	**5,216.0**
Дүн		**353,229.8**	**371,799.2**	**252,915.2**	**182,841.4**	**169,726.4**	**163,594.9**	**54,598.2**	**43,177.0**	**14,986.8**	**94,203.9**	**1,701,072.8**

Хавсралт № 02

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН 2017 ОНЫ ХОЁР ДАХ САНАЛ ХУРААЛТЫН ЗАРДЛЫН НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ

2017.08.04

№	Зардлын зүйл	Дүүрэг									НСХ	Дүн
		Сонгино-хайрхан	Баянзүрх	Баянгол	Хан-Уул	Сүхбаатар	Чингэлтэй	Налайх	Багануур	Багахангай		
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
3	Сургалтын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
4	Бичиг хэргийн зардал	1,385.0	1370.0	950.0	725.0	650.0	725.0	200.0	170.0	50.0	100.0	**6,325.0**
5	Шуудан холбооны зардал	1,840.0	1820.0	1260.0	960.0	860.0	960.0	260.0	220.0	60.0	100.0	**8,340.0**
6	Унааны зардал	4,575.0	4525.0	3125.0	2375.0	2,125.0	2375.0	625.0	525.0	125.0	250.0	**20,625.0**
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
8	Санал авах байр бэлтгэх зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	140.0	140.0	140.0		**2,520.0**
10	Томилолтын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		**0.0**
11	Саналын хуудас хүргэх зардал	925.0	915.0	630.0	475.0	425.0	480.0	160.0	230.0	150.0		**4,390.0**
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал	4,220.0	4200.0	2770.0	1960.0	1,740.0	1690.0	320.0	460.0	300.0		**17,660.0**
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	1,890.0	1890.0	1260.0	980.0	903.0	980.0	280.0	210.0	70.0		**8,463.0**
14	Болзошгүй зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	5,400.0	**5,400.0**
15	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	15,020.0	14860.0	9560.0	7880.0	7,080.0	6000.0	2160.0	1760.0	540.0	940.0	**65,800.0**
16	Сангалын хуудас устгах зардал											**0.0**
	Дүн	**30,205.0**	**29,930.0**	**19,905.0**	**15,705.0**	**14,133.0**	**13,560.0**	**4,145.0**	**3,715.0**	**1,435.0**	**6,790.0**	**139,523.0**

Хавсралт №3

№	Зардлын нэр	Эхний санал хураалт			2 дахь санал хураалт			Нийт		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	257.0	(7.0)			-	250.0	257.0	(7.0)
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	-	-	-			-	-	-	-
3	Сургалтын зардал	10,589.0	9,998.0	591.0			-	10,589.0	9,998.0	591.0
4	Бичиг хэргийн зардал	75,560.0	75,506.3	53.7	6,325.0	6,270.0	55.0	81,885.0	81,776.3	108.7
5	Шуудан холбооны зардал	74,690.0	74,495.4	194.6	8,340.0	8,179.3	160.7	83,030.0	82,674.7	355.3
6	Унааны зардал	86,760.0	86,702.6	57.4	20,625.0	20,600.0	25.0	107,385.0	107,302.6	82.4
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	47,865.3	47,497.4	367.9			-	47,865.3	47,497.4	367.9
8	Санал авах байр бэлтгэх зардал	80,600.0	80,526.8	73.2			-	80,600.0	80,526.8	73.2
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	2,520.0	2,170.0	350.0	2,520.0	2,520.0	-	5,040.0	4,690.0	350.0
10	Томилолтын зардал	300.0	300.0	-			-	300.0	300.0	-
11	Саналын хуудас хүргэх зардал	4,390.0	4,375.0	15.0	4,390.0	4,375.0	15.0	8,780.0	8,750.0	30.0
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал	17,660.0	16,960.0	700.0	17,660.0	16,960.0	700.0	35,320.0	33,920.0	1,400.0
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	8,463.0	8,420.0	43.0	8,463.0	8,460.0	3.0	16,926.0	16,880.0	46.0
14	Болзошгүй зардал	110,638.7	106,549.1	4,089.6	5,400.0	5,400.0	-	116,038.7	111,949.1	4,089.6
15	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	1,175,570.8	1,174,597.2	973.6	65,800.0	65,060.0	740.0	1,241,370.8	1,239,657.2	1,713.6
16	Саналын хуудас устгах зардал	5,216.0	5,216.0	-			-	5,216.0	5,216.0	-
НИЙТ ДҮН		**1,701,072.8**	**1,693,570.7**	**7,502.1**	**139,523.0**	**137,824.3**	**1,698.7**	**1,840,595.8**	**1,831,395.1**	**9,200.7**

Хавсралт №04

Нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/төгрөгөөр/

1.Эхний төсвийн гүйцэтгэл

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,000.00	257,000.00	(7,000.00)
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	-	-	-
3	Сургалтын зардал	10,589,000.00	9,998,000.00	591,000.00
4	Бичиг хэргийн зардал	75,560,000.00	75,506,257.00	53,743.00
5	Шуудан холбооны зардал	74,690,000.00	74,495,387.46	194,612.54
6	Унааны зардал	86,760,000.00	86,759,985.00	15,0
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	47,865,300.00	47,497,400.00	367,900.00
8	Санал авах байр бэлтгэх зардал	80,600,000.00	80,526,828.00	73,172.00
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	2,520,000.00	2,170,000.00	350,000.00
10	Томилолтын зардал	300,000.00	300,000.00	-
11	Саналын хуудас хүргэх зардал	4,390,000.00	4,375,000.00	15,000.00
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал	17,660,000.00	16,960,000.00	700,000.00
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	8,463,000.00	8,420,000.00	43,000.00
14	Болзошгүй зардал	110,638,700.00	106,549,100.00	4,089,600.00
15	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	721,626,400.00	720,952,800.00	673,600.00
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	126,644,400.00	126,644,400.00	-
17	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүний сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	327,300,000.00	327,000,000.00	300,000.00
18	Саналын хуудас устгах зардал	5,216,000.00	5,216,000.00	-
НИЙТ ДҮН		**1,701,072,800.00**	**1,693,613,172.46**	**7,459,627.54**

2.Дахин санал хураалтын

№	Зардлын нэр төрөл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Бичиг хэргийн зардал	6,325,000.00	6,270,000.00	55,000.00
2	Шуудан холбооны зардал	8,340,000.00	8,179,336.22	160,663.78
3	Унааны зардал	20,625,000.00	20,600,000.00	25,000.00
4	Саналын хуудас хүргэх	4,390,000.00	4,375,000.00	15,000.00
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	17,660,000.00	16,960,000.00	700,000.00
6	Мэдээ дамжуулах зардал	2,520,000.00	2,520,000.00	-
7	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	8,463,000.00	8,460,000.00	3,000.00
8	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын хоолны зардал	65,800,000.00	65,059,992.00	740,008.00
9	Болзошгүй зардал	5,400,000.00	5,400,000.00	-
	Нийт дүн	**139,523,000.00**	**137,781,778.22**	**1,741,121,78**